

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ийн БАГАЖ ТӨХӨӨРӨМЖ, ХЭМЖИЛЗҮЙН
ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:

- Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэгдсэн.
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

“Аймаг, хотын ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай” ЦУОШГ-ын А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025.09.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025.08.13

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Багаж төхөөрөмж, хэмжилзүйн инженер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжил ангилал, ТҮМ-5

Ажлын цаг:

Өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг Тэмүүжингийн гудамж Н-13

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

1. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго: Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжих хэрэгсэл, автомат станц, багаж, тоног төхөөрөмжийн хэвийн тасралтгүй ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, шалгалт тохируулга, засвар үйлчилгээ хийх, албан хаагчдыг сургаж дадлагажуулах, чадваржуулах ажлыг зохион байгуулах

Албан тушаалын зорилт:

1. Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын урт, богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай төрийн бодлого, төлөвлөлт, Засгийн газар, аймаг, орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
2. УЦУОХШ-ний ажлын хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдал болон холбогдох хууль, журам, дүрмийн хэрэгжилтийг хангах
3. Хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн ашиглалт, хадгалалтанд хяналт тавих
4. Хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлыг удирдан зохион байгуулах
5. УЦУОХШ-ний хэмжих хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжинд техник, технологийн шинэчлэлтийг нэвтрүүлэх
6. Хэмжлийн технологи мөрдөлтөнд хяналт тавих сургах, мэргэшил аргазүйн удирдлагаар хангах
7. Байгууллага, хэлтэсийн үйл ажиллагааг хэвийн явуулахад оролцох

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Монгол Улсын хууль, Засгийн газар, БОАЖЯ, ЦУОШГ-аас цаг уурын мэдээлэл, үйлчилгээний ажлын талаар гарсан тогтоол, тушаал, хөтөлбөр, удирдамж, журам, дүрэм, бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг судлан хэрэгжилтийг зохион байгуулна.	Гүйцэтгэл хувиар	Г, Х, Ш, Т
	Дэлхийн цаг уурын байгууллага /ДЦУБ/-ын зөвлөмж, Монгол улсын ус, цаг уур орчны шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, гүйцэтгэлийг нэгтгэн үнэлэх	Хэрэгжилт, хувиар	Г, Х, Ш, Т
	Засаг даргын мөрийн хөтөлбөр болон аймгийн дунд ба урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн	Хэрэгжилт, хувиар	Г

	хүрээнд тусгагдсан ажил үүргийн биелэлтийг хангах		
	“Байгууллагын архивын журам”, “Албан хэрэг хөтлөлтийн журам” –ын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилт хувиар	Г
	Салбарын үйл ажиллагаатай холбоотой хугацаатай бичгийн хариу өгөх, гэрээ дүгнэх, тайлан мэдээг заасан хугацаанд явуулах, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Хэрэгжилт, хувиар	Г, Х, Ш,Т
2 дугаар зорилтын хүрээнд	УЦУОХШ-ний хэмжих хэрэгслийг баталгаажуулах, шалгах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний биелэлт -95%-иас дээш байх	Г
	Салбар, нэгжүүдийн хэмжлийн технологи, заавар, дүрэм, стандартын мөрдөлтөнд хяналт тавих, зөрчлийг арилгах	Зөрчил илрээгүй байх	Г,Х
	Хэмжилзүйн нэгдмэл байдлын тухай хууль, бусад холбогдох хууль журмын биелэлтийг тайлагнах, албан бичгийн төсөл бэлдэх	Бодлогын баримт бичгийн зөрчил үүсээгүй байх	Г
	Тухайн жилд шаардлагатай байгаа багаж хэмжих хэрэгслийн захиалгыг хийх	Багаж хэмжих хэрэгслийн хангалтаас шалтгаасан тасалдал гараагүй байх	Г,Х
3 дугаар зорилтын хүрээнд	Шинжилгээний ажилд тэнцэхгүй актлах шаардлагатай багаж, хэмжих хэрэгслийн акт бичиж албаны өмч хамгаалах зөвлөл болон хэлтсийн даргад танилцуулах.	Хэмжлийн гологдол гараагүй байх	Г
	УЦУОХШ-д ашиглагдаж байгаа багаж, хэмжих хэрэгслийн нарийвчилсан судалгааг гарган тухай бүрт баяжилт хийх.	Судалгаа бүрэн хийгдсэн байх	Г
	Ашиглаж буй хэмжих хэрэгсэлд үзлэг үйлчилгээг тухай бүр хийнэ.	Төлөвлөгөөний биелэлт -100%	Г
	“Техник ашиглалтын паспорт” хөтлөх	Бүрэн хөтлөгдсөн байх	Г,Х

4 дүгээр зорилтын хүрээнд	Хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжинд гарсан гэмтэл, саатлыг тухай бүр арилгах	Хэмжлийн тасалдал гараагүй байх	Г.Х
	Ээлжит болон гэнэтийн шалган туслах ажлын хэсэгт орж өртөө харуулуудын багаж хэмжих хэрэгсэлд үзлэг үйлчилгээ хийх.	Үзлэг үйлчилгээнл бүрэн хамруулсан байх	Г.Х. Т
	Шинжилгээний ажлын талбай, төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлын төлөвлөж гүйцэтгэх	Хэмжлийн орчны стандартыг хангасан байх	Г.Х. Т
5 дугаар зорилтын хүрээнд	ЦУАС-ыг шинээр суурилуулах, үзүүлэлтүүдийг сайжруулах ажлыг шат дараатай гүйцэтгэх	ЦУАС-ыг суурилуулсан үзүүлэлтүүд сайжирсан байх	Г.Х.Т
	Инженер, техникийн албан хаагчдийн хэмжил хийх, боловсруулах үйл явцыг хөнгөвчлөх, хэмжлийн алдаа, эргэлзээг багасгах талаар техник, технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх	Хэмжлийн алдаа, эргэлзээ буурсан байх	Г.Х.Т
	Шинжилгээний ажлын талбай, хэмжлийн орчинг холбогдох стандарт, журмын дагуу сайжруулах	Хэмжлийн орчинг сайжруулхадаа дэвшилтэт технологи, арга нэвтрүүлсэн байх	Г
	Хэмжих хэрэгслийн үзүүлэлтүүдийг сайжруулах, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар техник, технологийг судлах	Хэмжих хэрэгслийн хадгалалт, хамгаалалт сайжирсан байх	Г.Т
	Шинэ хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийг ашиглах, суурилуулах ажлыг зохион байгуулах	Суурилуулж хэвийн ажиллагааг хангасан байх	Г.Т
6 дугаар зорилтын хүрээнд	Инженер, техникийн албан хаагчдад хэмжлийн технологи, хэмжилзүйн талаархи сургалт зохион байгуулах	Жилд 4-өөс доошгүй удаа зохион байгуулсан байх	Г.Т
	Шинэ хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийг ашиглах, хэмжих хийх талаар сургалт зохион байгуулах	Инженер, техникч нар ажиллуулж сурсан байх	Г.Т
	Шинээр ажилд орж буй хүмүүсийг дадлагажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр гарган ажилласан байх	Г

	Багаж тоног төхөөрөмж, автомат станцын үзлэг үйлчилгээг тогтмол хийхэд албан хаагчдыг сургаж дадлагажуулах	Инженер, техникч нар сурсан байх	Г
7 дугаар зорилтын хүрээнд	Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах	Зөрчил гаргаагүй байх	Г
	Өөрийгөө чадваржуулах чадвар хамрагдах мэргэшүүлэх, сургалтуудад	Хамрагдаж ур чадвараа ахиулсан байх	Г
	Байгууллагын дэргэдэх ажлын хэсгүүдэд ажиллах	Санаачилгатай үр дүнтэй ажилласан байх	Г
	Байгууллага болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцох	Бүрэн ирцээр оролцсон байх	Г

2. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр түүнээс дээш магистр /доктор/	
Мэргэжил	Цаг уурын инженер 053210	
	Цаг уурын мэдээлэл,прогноз 053212	
	Электроникийн инженерчлэл 071401	
Мэргэшил	Цаг уурын багаж хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх эрхийн үнэмлэх авсан. Мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	УЦУОХШ-ний аль нэг салбарт 5-аас доошгүй жил тогтвортой ажилласан байх.	
	Цаг уурын ажиглалт хэмжилтийн технологи сайн мэддэг байх. Электроник болон сүлжээ, программ ашиглалтын мэдлэгтэй байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> Байгууллагын болон салбарын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг үнэлэх Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> Судалгааны дүнд тулгуурлан салбарын хөгжлийн зорилтыг тодорхойлох Тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> Хуульд нийцсэн шийдвэр гаргах Шийдвэрийн төслийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж шийдвэрийн хувилбарын

		талаар зөвлөх
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> Албан хаагчдын санал бодлыг сонсож, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих Албан хаагч бүртэй тэгш хүртээмжтэй харилцах, ажиллах
	Бусад	<ul style="list-style-type: none"> Албан хэрэг хөтлөх, боловсруулах чадвартай байх Компьютерийн өргөн хэрэглээний болон салбарын үйл ажиллагаанд ашиглагддаг программ, технологиудыг ашигладаг байх Англи хэл эсвэл бусад гадаад хэлнээс мэргэжлийн дагуух эх сурвалж, мэдээллийг ашигладаг байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

1. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Цаг уурын өртөө хариуцсан инженер-8
- Цаг уурын ээлжийн техникч-32
- ХААЦУ-ын харуулын техникч -10
- Ус судлалын харуулын техникч -8

Нийт -58

Бусад харилцах субъект:

- ЦУОШГ-ын Улсын сүлжээ, Уур амьсгалын үйлчилгээний хэлтэс
- Онцгой тохиолдолд бусад субъект

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал: *Ауним нөөцийн анхтан*
.....
С. Таягалан

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

Байгууллагын нэр: *УУУОШГ*
Шийдвэрийн огноо: *2025.08.13*

Дугаар: *8/44*

2025 оны 8 дугаар сарын 13-ны өдөр

